

Усны хомсдол ба цөлжилт

Цөлжилт, газрын доройтол, ган гачиг нь усны хүртээмж, хэмжээ, чанарт сөрөг нөлөө үзүүлэх бөгөөд эдгээр нь эцэстээ усны хомсдолд хүргэнэ.



Монгол орны хэмжээнд 2007 онд явуулсан гадаргуугын усны тооллогын дүнгээр нийт 5,128 гол, горхины 852 (16.6%), 9,306 булаг шандын 2,277 (24.5%), 3,747 нуур, цөөрөмийн 1,181 (31.5%) ширгэж үгүй болсон байна (Монгол орны уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээний тайлан, 2009).

Цөлжилтийн нөлөө газар авснаар усны хомсдол цаашид нүүрлэх нь гарцаагүй бөгөөд хуурай гандуу газар нутагт үндэстэн хоорондын болоод улс төрийн түгшүүрт байдал улам бүр нэмэгдэж, улс хоорондын хилийг бүрдүүлдэг усны нөөц бүхий газарт маргалдаан гарах явдалд улам бүр нэрмээс болно. Зарим газарт газрын доройтол нь хүн амын асар том хэмжээний шилжих хөдөлгөөнийг өдөөж, бүхэл бүтэн тосгоны хүн ам тэр чигээрээ газар тариалангийн газраа орхин явж хүн ам нь хэт төвлөрсөн хотууд руу шилжин нүүж байна. Цөлжилтийн эсрэг үйл ажиллагаа явуулахгүй бол дараагийн 10 жилд 50 сая орчим хүн орон гэргүй болох эрсдэлтэй (UNU 2007) байна. Газрын ба усны тогтвортой менежментийн бодлогыг хэрэгжүүлэх нь эдгээр улам бүр хүндэрсээр байгаа асуудлыг даван туулахад ихээхэн хувь нэмэр оруулах болно.

Усны хомсдолын нөлөө хөрсөнд удаан хугацаагаар үйлчилнэ

Цөлжилт гэдэг бол уур амьсгалын хэлбэлзэл, хүний үйл ажиллагаа зэрэг олон хүчин зүйлээс үүдэх хуурай гандуу газар нутаг дахь газрын доройтол юм. Усны хомсдол гэдэг нь байгаа усны нөөц ба хэрэглээ хоорондын тэнцвэргүй байдал урт хугацааны турш үргэлжлэх явдал юм. Байгалийн шалтгаан ба хүний үйл ажиллагааны улмаас үүдэн бий болох усны хомсдолын тохиолдол нэмэгдэх нь газар ба хөрсний чанар, хөрсний бүтэц, органик бодисийн агууламж, эцэстээ хөрсний чийгшлийн хэмжээнд урт хугацаанд нөлөөлж, цөлжилтийн нөлөөг эхлүүлэх буюу улам бүр ихэсгэх болно. Газрын доройтлын шууд нөлөөгөөр, цэвэр усны нөөц ширгэх, ган гачиг ба элс, шороон шуурга болох давтамж нэмэгдэх бөгөөд усны урсгалын систем буюу усжуулалтын алдаатай горимоос шалтгаалж үер ихээр болж байна. Эдгээр үзэгдэл үргэлжилсээр байвал хөрсний шимт байдал огцом буурч, ургамлын нөмрөгийн алдагдал илүү хурдацтайгаар явагдана. Цаашлаад гадаргын болоод гүний ус бохирдох,

хур тунадас нэмэгдэх, давсжилт, хөрсний шүлтлэг байдал ихсэх зэргээр газар ба усны доройтол явагдана. Байдлыг үеэ өнгөрөөсөн, газрын тогтворгүй менежментийн арга хэрэгсэл нэрмэж байна. Хэт ихээр тариалах, бэлчээрийн доройтол, ой модны хомсдол нь үржил шимтэй дээд давхаргын хөрс ба ургамлан бүрхүүлийг багасгаснаар усны нөөцөнд дарамт учруулж, усжуулалттай газар тариаланд илүү их найдах хэрэгтэй болгодог. Томоохон нууруудыг тэтгэдэг гол мөрнүүдийн урсгал багассанаар төв Ази, хойд Африкт тус тус орших Арал тэнгис, Чад нуур гэсэн байгалийн усан цөөрмийн эзлэх гадаргуугийн талбайн хэмжээ маш хурдацтайгаар багасч байсан тод жишээ байдаг.

Газар тариаланд тулгарч байгаа сорилт

Хуурай гандуу газар нутагт хүнсний аюулгүй байдлыг хангах зорилтыг хангахын тулд тогтвортой газар тариалангийн бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй ба энэ нь орон нутгийн хүн амд, ялангуяа ядуу ба хөдөөний хүмүүст хамгийн их ашиг тусаа өгнө. Өнөөгийн байдлаар усжуулалттай газар тариалан эрхэлдэг ихэнх улс оронд хамгийн их хэмжээний усыг хэрэглэж байгаа бөгөөд энэ нь дараагийн 30 жилд 14 хувиар өсөх магадлалтай байгаа тул энэхүү нэмэгдэлд олон хувилбартайгаар, уян хатан байдлаар дасан зохицох нь нэн чухал болж байна.

Газрын хэрэглээ, үр тарианы ургамлыг тариалах хэв загварт өөрчлөлт хийх нь дасан зохицох нэг хувилбар байх болно. Үүнээс гадна ганд тэсвэртэй, ус бага хэрэглэдэг үр тарианы ургамлыг тариалах нь бас нэг боломж юм. Өмнөх жилийн ургац хураалтын үлдэгдэл болох тарианы ишийг авч хаялгүй талбайд үлдээснээр усны нэвтрэх чадварыг сайжруулж, салхи, усны элэгдлийг багасгадаг. Биобордоо зэрэг хөрсийг бордох шинэ арга технологи гарч ирж байгаа нь найдвар төрүүлж байгаа бөгөөд эдгээр нь хөрсний нүүрстөрөгчийн шингээлттэй холбогдолтой чийг барих чадварыг сайжруулна.

Өөр нэг боломж бол нэг наст үр тарианы ургамлын тариалангаас олон наст буюу хагас олон наст тариалан руу шилжих явдал юм. Ийм төрлийн газар тариалан эрхэлснээр эрчим хүчийг бага зарцуулж, цаашлаад дээд давхаргын хөрсийг бага гэмтээн хөрсний элэгдлээс сэргийлнэ. Олон наст үр тариаг ашиглах өөр нэг ашигтай тал нь ус хөрсний гүний давхаргуудын шим тэжээлд илүү хялбар хүрч болдог боломж юм.

Зарим газар нутагт газар тариалангийн эрхэлж байгаа өнөөгийн хэв маяг нь усны хэрэглээний тухайд тогтвортой биш байна. Иймд тэнд газар ашиглах хэв маягаа өөрчлөх талаар ярьж хэлэлцэх хэрэгтэй байна. Бага талбай бүхий тариалангийн талбайг ой, бэлчээр зэрэг газар ашиглалтын өөр хэв маягт шилжүүлснээр газрын доройтлыг багасгаж дараа нь урт хугацаагаар газар тариалан эрхлэх бололцоог сэргээнэ.

Хуурай гандуу газар нутагт газар тариалан ба амьжиргааны бусад арга хэлбэрийг анхаралдаа авснаар ГУНТМ-ийг бий болгох арга замууд (Адийл, Сафриэлээс авав)



Газар тариалангаас гадна өөр юу хийж болох вэ

Газар, усны менежментийн нэгдсэн бодлогыг бий болгосноор эцэстээ дэлхийн түвшинд байгаль орчин, нийгэм-эдийн засгийн хувьд ашигтай байх болно. Газрын тогтвортой менежментийн үйл ажиллагаанаас хот хөдөөгийн хүн амын аль алинд нь ашиг тустай. Энэ нь мөн дэлхийн түвшинд ач холбогдол бүхий ХАА-н биологийн олон янз байдал, уян хатан агро-экосистемийг дэмжиж байдаг. Үүнд, бэлчээрийн газар ба ойн нөөц; амьдрах орчин ба генетикийн нөөцийг хадгалах; газрын доройтол ба цөлжилтийн явцыг усны сайжруулсан чанар, хангамжаар дамжуулан эргүүлж сэргээх зэрэг орно. Газрын тогтвортой менежментийн үйл ажиллагаанд:

- Усны амьтан үржүүлэх аж ахуй, загас агнуур, усжуулалтын систем зэргээр дотоодын хэрэглээний өөр хоорондоо харилцан тэнцвэрийг хангасан цэвэр усны нөөцийн менежментийг дэмжих;
- Гүний усны түвшинг буцааж байранд нь оруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Ус чийг бүхий газар нутгийг хөдөө аж ахуй ба суурин газар болгож хувиргах үйл явцаас хамгаалах;

- Хөрсийг бүтээх арга замаар хамгаалах хөрсний тогтвортой менежментээр дамжуулж хөрсний бүтээмжийг сэргээх, хөрсний элэгдлээс хамгаалах;
- Органик хөдөө аж ахуй, агро-ойн аж ахуй зэрэг ургац хураах тогтвортой арга технологийг ашиглах зэрэг үйл ажиллагаа багтана.

ГУНТМ-ийн үр өгөөж бүхий битүү тойрог/цагираг



ГУНТМ-ийн үр өгөөж бүхий битүү тойрог нь газрын нөхцөл байдлыг сайжруулахаас эхэлнэ

Байгаль орчин ба байгалийн баялгийн тогтвортой менежментийг улам бүр сайжруулах зорилгоор НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц нь эдгээр арга хэмжээг ихээхэн дэмжиж байдаг. Ингэж дэмжиж байгаа асуудлын үндсэн үзэл санаа нь газрын ба цэвэр усны нөөцийг хамгаалах, түүнийг нөхөн сэргээх нь байгалийн баялаг, байгаль хамгаалах зорилготой бодлогын гол бүрэлдэхүүн хэсэг болдог оршиж байна. Өөр нэг бүрэлдэхүүн хэсэг нь орон нутгийн ард иргэдийн ган ба усны хомсдол, газрын доройтолтой холбоотой үүсэж байгаа бэрхшээлийг даван туулах чадамжийг дээшлүүлэх явдал юм.

Дээрх үйл ажиллагааг уур амьсгалын нөлөөг бууруулах үйл ажиллагаа, мэдээллийн солилцоо, эрт бөгөөд шуурхай анхааруулах системийн тусламжтайгаар хэрэгжүүлнэ. Эдгээр үйл ажиллагааг НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенцын 10 жилийн Стратеги төлөвлөгөө (2008-2018)-ний хүрээнд хэрэгжүүлэх бусад үйл ажиллагаа дэмжиж өгнө. Үүнд:

- Усны хомсдол, гангийн талаарх харилцан зохицуулах санал санаачлага, мөн үүнтэй холбоотой хоол хүнсээр хангагдах эрх, шилжих хөдөлгөөн, ган гачиг, уур амьсгалын өөрчлөлттэй дасан зохицох зэрэг санал санаачлагыг дэмжиж зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, чадавхийг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Индикатор, менежментийн загвар, судалгааны загвар, оролцооны загвар зэргийг хамруулсан бодлого ба судалгааны арга хэрэгслийг харилцан уялдуулах, усны хэрэглээний асуудлаар өөр хоорондоо адилгүй хуулийн тогтолцоо бүхий улс орнуудын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааг дэмжих
- Өсөн нэмэгдэж байгаа усны хомсдолын эсрэг хэрэгжүүлэх Үндэсний хөтөлбөрийг сурталчлах, дэмжих, хэрэгжилтийг хянах талаар холбогдол бүхий олон улсын байгууллагад хандах ажиллагааг хангах

Дээр дурьдсан тэргүүлэх үйл ажиллагаануудыг харилцан уялдаатай хамтын ажиллагаа, НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага, ДЭМБ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (UN-Water, FAO, ISDR, OHCHR, UNHabitat, WHO, UNU, UNHCR, IWCN, UNDP, UNEP) зэрэг байгууллага, механизмын оролцоотойгоор, мөн Риогийн гурван конвенц болох Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаархи НҮБ-ын суурь Конвенц, Биологийн төрөл зүйлийн тухай Конвенцийн хэрэгжилт дэмжиж ажиллах болно.